

## МОНГОЛ ГАЗРЫН ЗУРГИЙН ЗАРИМ ШИНЭ ОЛДВОР ХИЙГЭЭД ЗУРАГТ ХОЛБОГДОХ БАС БУС ЗҮЙЛИЙН ТУХАЙД

Ц.Шагдарсүрэн

Уламжлалт монгол газрын зургийн судалгаа Европ дахинаа зуу гаруй жилийн өмнөөс, Ази дахинаа зуугаад жилийн өмнөөс гарчээ. XX зууны дунд үеэс уг судалгаа хамрах хүрээний хувьд улам өргөжихийн хажуугаар уламжлалт газрын зургийг зурах зарчим, онцлогийг тодруулах судалгаа нарийссан гэж үзэх бүрэн үндэстэй. Судалгааны үр дүнд хаа хаана ямар ямар зураг байгаа талаар зохих мэдээлэлтэй болж улмаар цуглуулах, судлах ажил эрчтэй өрнөж эл ажилд гадаад дотоодын олон орны олон эрдэмтэн анхаарсаар ирлээ. Энэ бол судалгаа өндөрлөсөн хэрэг бус харин ч хамрах хүрээг өргөсгөхийн хамт, судалгааг улам нарийсгах шаардлага буй гэсэн үг. Үүнд: судалгаанд гүйцэд буюу огт хамрагдаагүй зургийн зүйл, зургийн орон зай, цаг хугацааны онцлог болон зурагт тэмдэглэгддэг газар дээрхи биет зүйл хийгээд зурагт шууд ба дам холбогдох, цагийн эрхээр бүдгэрэн мартагдах бас бус баримт зэрэгт анхаарах шаардлага гарч байна. 40 жилийн өмнөөс уламжлалт монгол газрын зурагт холбогдох баримт, судалгаатай танилцаж 1976 оноос өгүүлэл нийтлүүлж<sup>1</sup> ирсэний учир цаашид хэрхэх тухай санал бодлоо хэлэхэд тохиолдлын буюу сонирхогч хүн гэж үзэхгүй буй заа. Тэгвэл цаашид давын өмнө юунд анхаарах талаар саналаа толилуулая.

1. Хувь хүний гар дээр, орон нутагт, гадаадын эрдэмтэдийн цуглуулгад гэх зэргээр судалгаанд гүйцэд бус болоод огт хамрагдаж байгаагүй газрын зураг энд тэнд олон буй. Жишээ нь: Монголын анхны доктор, академич Н. Жагваралын номд орсон хоёр зураг<sup>2</sup> (2-р хавсралт: зураг 1-а, 1-б), 1959 оны Олон Улсын монгол хэл бичгийн эрдэмтэдийн хуралд Я. Цэвэлийн тавьсан “Монгол албан бичгийн уламжлал” илтгэлийн хавсралтад орсон нэг зураг<sup>3</sup>... зэргийг дурдаж болно. Харин

<sup>1</sup> Ts. Chagdarsuren(g), *La connaissance géographique et les cartes des Mongols*, - Studia Mongolica, Tom. III(11), Fasc. 20, Ulaanbaatar, 1976, pp. 343-370.

<sup>2</sup> Нэг нь: тодорхой нэр, огноогүй, Орос Улстай зах нийлсэн хоёр талын овооны зураг, нөгөө нь: мөн л нэр нь тодорхойгүй, Олонаа өргөгдсөний 11-р оны зураг.

<sup>3</sup> Бадаргуулт төрийн 33-р онд үйлдсэн Халхын Сэцэн хан аймагийн туслагч жанжин бэйс Пүрэвжавын хошууны зураг. Энэ зураг Я. Цэвэлийн 1937 оны номзүйн бүртгэлийн 143, 2011 онд Японд хэвлэгдсэн номзүйн бүртгэлийн 181-д буй. Дараахи номзүйн бүтээлээс тодруулан үзнэ үү:

[Я. Цэвэл], *Монгол улсын номын сангийн Азийн ангид бүхий монгол ангийн бичмэл ба дармал номын бичигүүдийн бүртгэл*, (БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэн, Монголын хувьсгалын арван зургаан жилийн ойд зориулан нийтлэв), Улаанбаатар, Монгол Улсын 27-р он [(Монгол бичигээр) 261 тал]: Газарзүй ба эдийн засагийн анги [1-514 нэгж90-152-р тал], 106-р тал; *Catalogue of the Mongolian Manuscripts in the National Library of Mongolia*, Compiled by Ch. Narantuya & D. Enkhtungalag, Edited by Tachibana Makoto, - Bulletin of Waseda Institute for Mongolian Studies, A Separate Volume, Waseda University, 2011, [104 pp, see. 14-27; 28-33 pp.], p. 20.

### Ц.Шагдарсүрэн

Улаанбаатар их сургууль  
shandastu@yahoo.com

### С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

тэр зургуудын зарим нь уг эхээрээ одоо байсан газраа байгаа эсэх нь тодорхойгүй ч гэрэл зургаар лав үлдэн иржээ.

Энэ далимаар холбогдуулан тэмдэглэхэд уг газрын зургаас гэрэл зураг татах ажлыг тэр үеийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн бүрэлдэхүүнд байсан Гэрэл зургийн лабораторийн зурагчин, германд сурч байсан “шилэн” хэмээх Гомбожав, Чойжинням нар гүйцэтгэж байсан<sup>4</sup> бөгөөд голдуу шилэн дээр буулгадаг, одоогийн зургаас дутах юмгүй сайхан зураг татдаг хүмүүс байж билээ.

Үүнээс гадна академич Б. Я. Владимирцовын судалгаанд орсон зураг<sup>5</sup>, В. Котвич (W. Kotwicz)-ийн цуглуулгад буй арваад зураг зэргийг олж үзэх, судлах боломж нээгдсээр байна. В. Котвичийн цуглуулгын тухайд саявтархан хэвлэгдсэн хоёр номын нэгэнд нь есөн зургийг тухай мэдээ болоод заримд нь холбогдох судалгаа<sup>6</sup>, нөгөөгийнхи нь хавсралтад нэг зураг<sup>7</sup> тус тус багтжээ (2-р хавсралт: зураг 2-а, 2-б, 2-с).

Бас хөдөө орон нутгийн музейд хадгалагдаж буй зургууд байна. Жишээ нь: Баянхонгор аймагийн музейд Өртөөний нэлээд тодорхой зураг, мөн Дундговь аймагийн музейд Сэцэн хан аймагийн Боржигин сэцэн ван, Түшээт хан аймагийн Төрболдын хошууны гэх хоёр зураг хадгалагдаж буй зэргийг дурдаж болно<sup>8</sup> (2-р хавсралт: зураг 3-а, 3-б). Эндээс Төрболдын хошууны зураг нь *өргөх цэс*-т тусгай байдаг гол гол мэдээллийг зургийн хоёр хажуугаар тэмдэглэсэн зэргээрээ нэлээд онцгой.

2. Уламжлалт монгол газрын зурагт суурь болж ирсэн, чухам газар дээрээ байгаа тэмдэглэгдэхүүнүүдийг боломжийн хэрээр баримтжуулах ажлыг хийвэл зохилтой байна. Жишээлбэл: Түшээт хан аймагийн Зоригт вангийн хошуунд буюу БНМАУ-ын уулын нэрээр нэрлэсэн 1925 оны засаг захиргааны хуваариар Гүнцэл чивчид уулын хошуу, одоогийн Төв аймагийн Эрдэнэсант сумын нутагт буй хошууны дээсийн бичээсийг жишээлэн дурдаж болно (2-р хавсралт: зураг 4). Хошууны дээсийн энэ мэт бичээс энд тэнд олон буй.

<sup>4</sup> Гомбожав гуай гэж том хүнхэр шил зүүдэг, зураг угаах үедээ бас нэгэн шил давхарлан хийдэг, гангандуу хүн байж билээ. Бас тэр цагийн уулгалын үед “аавын хаалга” татаад гарч ирсэн гэдэг. Гэргийгий нь Хунданхүү гэнэ, надаас эгчмэд Буянт гэдэг охинтой, надтай чацуу Төмөрхүү гэдэг хүүтэй, сайхан айл байж билээ. Харин Чойжинням гуайг танихаас цаашгүй. Гэрэл зургийн лабораторид байсан гэрэл зургийн асар олон шил (негатив)-ийн нэлээд хэсэг нь сүүлд ШУА-ийн аж ахуйн хашаа хэмээх Таван буудлын түлээний хашаанд ил байж байгаад үрэгдсэн, нэг хэсэг нь сүүлд 1980-аад онд зурагчин Дагважамцын өрөөнд байсан, дараа нь тэгээд ...

<sup>5</sup> Б. Я. Владимирцов, *Объяснения к карте Северо-Западной Монголии*, - ИИРГО [Известия Императорскаго Русскаго Географическаго Общества], том. XLVII, СанктПетербургъ, 1911, стр. 491-495в

<sup>6</sup> Inoue Osamu, *Old maps showing Erdene Zuu Monastery from the archive of Prof. W. Kotwicz*, - in Book: *In the Heart of Mongolia (100<sup>th</sup> Anniversary of W. Kotwicz's Expedition to Mongolia in 1912)*, Editors: Jerzy Tulisow, Osamu Inoue, Agata Bareja-Starzyńska, Ewa Dziurzyńska, Crakow, 2012 [413 + pp.], pp. 207-244.

<sup>7</sup> В. Л. Котвич, *Из эпистолярного наследия*, Улаанбаатар, 2011, [414 стр.], см. стр. 407.

<sup>8</sup> М. Бямбажав, Ж. Мөнхцэцэг, *Дундговь аймгийн музейн сан хэмрөгөөс* (From the Exhibits of Dundgobi Aimag Museum), Улаанбаатар, 2011, [108 тал], 26-р тал.

Үүнчлэн түүхийн хэсэгхэн үеийн гэрч болсон, одоо олон хүн мэдэхгүй хоёр улсын хилийн тэмдэгт багана зэрэг ч энд хамаарна (2-р хавсралт: зураг 5-a, 5-b, 5-c, 5-d).

3. Одоогоор бидний судлагдахуунд хамаагүй мэт санагдавч монгол газрын зураг гэдэг ойлголтод хамаарах буюу орчин цагийн газрын зураг үйлдэхэд эх тэмдэглээ болж байсан, өндөр газар суулгасан буюу өндөр модон дээр харагдахуйцаар уртасган хадсан тэмдэг мод зэрэг зүйлийн олонхи нь байхгүй болсон ч цагийн эрхээр цөмөөрөө үгүй болохынхи өмнө амжиж үлдсэн ганц нэгийг нь ч зураглах зэргээр боломжийн хэрээр авч хадгалах хэрэгтэй гэж санана (2-р хавсралт: зураг 6).

Энэ мэтээр уламжлалт монгол газрын зураг судлагч, сонирхогч хүн бүр дор бүрээ хичээн чармайж Монголын аймаг хошуудын зурагт үндэслэж бүх аймаг хошууны зургийн нийлүүлэн нийлүүлсээр түүхэн үе үеэр нь буюу аймаг хошууны хуваари бүхий засаг захиргаатай байсан Манж Чин Улс, Богд хаант Монгол Улс, (аймаг хошуудыг уулын нэрээр нэрлэсэн 1925-1931 оны буюу) БНМАУ-ын эхин үе гэх мэтээр тус бүр үечлэж бүхэл нэгэн цогц болгоход анхаарч гэмээ нь бидний сонирхон зорьж буй ажлын бас нэгэн чухаг үр дүн гарна. Үүний тулд эхний шатанд одоогоор бидэнд мэдэгдэж буй бүх зургийн цаг хугацаа, орон зай, хаа байгаа, судалсан эсэх гэх зэрэг бүх мэдээ сэлтийг багтаасан жагсаалтыг үйлдэж холбогдох үе үеийнхи нь аймаг хошууны зураг дээр байх байхгүйгээр нь тэмдэглэх хэрэгтэй санагдана. Энэ бол цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардсан амаргүй ажил тул дараагийн шатны төсөл болгохгүйгээр гүйцэтгэх аргагүй. Энэ нь Монголын түүхийн салбарт ч, түүхэн газарзүйн хүрээнд ч чухамхүү бодот баримтад түшсэн судалгааны үнэ цэнтэй ажил болох юм. Бас зөвхөн Монгол гэлтгүй зах нийлж, нутаг савласан хөрш орнуудын түүхэн газарзүйд нэгэн адил чухал ач холбогдолтой.

[Өдгөө нийтээр сайн мэдэхгүй зарим холбогдох судалгааны номзүй болон монгол газрын зураг, түүнд шууд болон дам хамаарах зарим хэрэглэглэхүүнийг толилуулсан хоёр хэсэг хавсралтыг ард дагалдуулав]

1-р хавсралт:

## Холбогдох зарим судалгааны талаархи мэдээ

Монголын аймаг хошуудын гарал, засаг захиргааны зохион байгуулалт зэрэгт холбогдуулан үзвээс зохилтой ч одоо олон хүн сайн мэдэхгүй дараахи судалгааны гурван өгүүлэлийг О. Латтиморе (Owen Lattimore) авгайн санаачлагаар Chang Chih-yi гэдэг хүний эмхэтгэсэн номзүйн бүтээлээс цоолдож аван танилцуулж байна.

[This bibliography, made under the direction of Dr. Owen Lattimore, for the International Secretariat of the Institute of Pacific Relations is reprinted from the *Royal Central Asian Society*, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 1-49.]

① Kuan Chou-hua, *Meng-ku meng-chi chih-tu shu-liao* (Survey of Mongol League and Banner Organization), - "Hsin-ya-his-ya" (New Asia), Vol. V, No. 6 (June, 1933), pp. 53-57.

Comments:

A sketchy appraisal of Mongol banner and League. Emphasis on league organizations, whose inefficiency, according to Kuan, was the result of lack of express provisions for strengthening the mechanism of the league, as can be seen from the statutes of the Board of Frontier Affairs. For instance, there was practically no permanent staff for the league administration.

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 8-9]

② Ling Shui-sheng, *Chung-kou pien-cheng-chih meng-ch'i chih-tu* (League and banner institution as China's frontier policy), "Pien-cheng kung-lun" (Frontier Affaire), Vol. II, Nos. 3-10 (Oct. 1943), pp. 1-12.

Contents:

1. Origin of banner organization. 2. Functioning of banners. 3. Tribes, leagues and banners. 4. Functioning of leagues. 5. "Aimaks" under the direct control of the central government. 6. Banner organization of Moslems. 7. Basic difference between "Eight Banners" and Mongol banners. 8. Present situation of leagues and banners.

Comments:

... In his opinion, the league and banner organization represented one of the four major frontier institution in the past. The other three were: (1) the policy of changing the authority over tribes-people from native chief-tains to regular Chinese officials, as practiced in the south-west with regard to the Miao, Yao and so forth; (2) the theocratic

institution; and (3) the tribal organization. It was designed to split each big Mongol tribe into several artificial banners – a policy of “divide and rule”

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, p. 10 ]

③ To Chin, Wen K'ang and others, *Ch'ingting Li-fan Yuan tse-li* (Official Regulation Governing the Board of Frontier Affairs), compiled in 1911, enlarged in 1825, revised in 1890-91, 64 chüan.

Comments:


This voluminous collection of statutes of the Manchu Court relating to Mongol and Tibetan affairs had been until recently the basic civil and criminal code in Mongolia. A Russian translation by Stefan Lipotzov, *Ulozhenie Kitaiskoi paboty Vneshnykh snoshenii*, 2 vols., St. Peterburg, 1828, is available, although many new revisions made during the years 1833-41 are still left untranslated.

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 12-14]


[Тодруулах нь: Монголд зориулсан 64 зүйл бүхий хууль зүйлийн бичиг: Хуулийн хамаарлаар авч үзвэл 51 хэсэгт хуваан үздэг. 1-р чüан: List of Mongol Leagues and banners.... , 61-62-р чüан: Tibetan affairs, 63-р чüан: Russian affairs.... гэх мэт (Ц. Ш.)]



Монгол газрын зургийн зарим шинэ олдвор хийгээд зурагт холбогдох бас бус зүйлийн тухайд



1-а. Н. Жагваралын докторын зэрэг хамгаалах зохиолын хавсралт зураг



1-б. Н. Жагваралын докторын зэрэг хамгаалах зохиолын хавсралт зураг






2-а. В. Котвич (W. Kotwicz)-ийн цуглуулгаас






2-б. В. Котвич (W. Kotwicz)-ийн цуглуулгаас





2-с. В. Котвич (W. Kotwicz)-ийн цуглуулгаас





3-а. Дундговь аймагийн музейн үзмэр дэхи зураг






3-в. Дундговь аймагийн музейн үзмэр дэхи зураг



4. Хошуу нутгийн захын овоог тэмдэглэсэн чулууны бичээс





5-a – 5-d. Монгол Улсын түүхэнд холбогдох хилийн хоёр чулуун багана





6. Орчин цагийн газрын зураг хийхэд цэг болгож ашигласан  
тэмдэгт мод

## SUMMURY

The research on traditional Mongolian maps was first done over a hundred years ago in Europe and about a hundred years ago in Asia. Since the mid of XX century scope, this kind of research has been broadened into the identification of the principles for traditional hand drawn maps and as a result of these researches by the foreign and Mongolian scientists have been attracted to collecting and exploring maps.

I, as a researcher who has been introduced to facts and studies of traditional maps for over 40 years and has published research articles since 1976, am willing to express my opinions on the future process of the map study. That's why, first of all, I am writing about the aspects of the study that should be paid more attention on in the future.

1. There is considerable number of maps that have partly or never been explored because they have been kept by individuals or foreign scholars, or in local areas. Though it is not clear whether these maps are kept originally in the hands of the owners, some of them are in the photo forms. In addition, there are maps that are kept in local museums.

2. It is required to document the significates or signs on the exact sites which have been the foundation for traditional maps.

3. Many of the signs, that were foundations for creating modern maps, have been disappeared now. It is not so relevant to our research at present but relevant to the concept of the Mongolian map. Therefore, we need to keep and designate the ones that are left. In this way, traditional Mongolian map researchers can contribute much to the field of complex studies in the stages as Manchu Qing Dynasty, Bogd Emperor and the People's Republic of Mongolia. In order to reach the goal, first of all, we should do the list of all the data and facts as dates, locations, significates and covered territories of the maps which we have now. Since it will take much time, money, there should be subsequent projects to be implemented on the field. The completion of the projects will be significant for not only Mongolian but also neighboring countries' historic geographies.